



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/БЗ

Улаанбаатар хот

Байгууллагын дотоод үнэлгээ зохион байгуулах
Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.1.1, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 5 дугаар бүлгийн 335 дугаар зүйлд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын засаглалын төлөв байдал, дотоод үнэлгээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2. Байгууллагын дотоод үнэлгээг удирдамжийн дагуу зохион байгуулж, үнэлгээний цахим маягтыг ашиглан үнэн зөв, бодит мэдээлэлд тулгуурлан, чанар, үр дүнтэй байдлаар тогтоосон хугацаанд тайлагнахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
1763 дугаар захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Л.Санжийжамц	Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд:	Б.Отгонжаргал	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Ц.Мягмарсүрэн	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Н.Өлзийцэцэг	Архивын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ш.Бат-Өлзий	Цэргийн штабын дарга
	Б.Гэрэлцолмон	Гадаад харилцаа өргөдөл, гомдол хариуцсан Ахлах мэргэжилтэн
	Н.Батцэнгэл	Эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн
	Д.Оюунбаатар	Захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хороо хариуцсан мэргэжилтэн
	А.Золзаяа	Хүний нөөц, төрийн албан хаагчийн ёс зүй, шагнал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Одбаяр	Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн